# ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ХОРШОО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Э.БАДАМХАНДЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ЗОРИЛТ 1. “ХҮНС ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1 Хүнс худалдаа үйлчилгээ хөнгөн үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах, удирдан зохион байгуулах. | Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга, удирдан зохион байгуулсан байна. | Бодлого шийдвэрийг 2-р улиралд 2 удаа, 4-р улиралд 1 удаа давхардсан тоогоор 78 иргэнд хүргэж зөвлөгөө өгсөн. | Төр засгаас гарч буй бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх. | Хоол үйлдвэрлэл, хүнсний худалдаа эрхлэгч 64 иргэнд хоол үйлдвэрлэл, талх нарийн боов, бүтээгдэхүүний хадгалалт, худалдаа, үйлчилгээнд тавигдах дотоод хяналт, зохистой дадал, хүнсний аюулгүй байдал, холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг дагаж мөрдөж ажиллах талаар арга зүйн зөвлөгөө өгч, гарын авлага бэлтгэн хүргэсэн.<br>Хүнсний аюулгүй байдлын 3 сарын аяны хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газар ЗДТГ хамтран 2024 оны 5-р сарын 24-ний өдөр хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч, хоол үйлдвэрлэл эрхлэгч, хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 40 хүнд сургалт зохион байгуулсан.<br>Хүнс, хөдөө аж ахуй газрын дарга, Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга нарын хамтарсан 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Жуулчны бааз, амралтын газруудад нэгдсэн хяналт, тохирлын үнэлгээ хийх тухай удирдамж”-ийн дагуу сумын ЗДТГ-тай хамтран 11 жуулчны бааз, амралтын газруудад хяналт, шалгалт болон тохирлын үнэлгээ хийж ажилласнаас 2024 онд шинээр 3 | 2024.03.01<br>2024.12.25 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | жуулчны бааз үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Жуулчны 11 баазын гал тогоонд ажиллаж байгаа 33 ажилтанд үйлчилгээний газрын баталгаажуулалтыг "Монгол Улсад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журам"-ын 5, 6 дугаар схемийг хэрэглэн явуулах бөгөөд тохирлын үнэлгээнд MNS 6043:2019 стандартын шаардлагын дагуу бэлтгэсэн үнэлгээний хуудсыг ашиглан стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор үнэлж, шаардлагатай бичиг баримтуудыг иргүүлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Орон нутгийн уламжлалт хоол, идээ ундааг дотоод, гадаадын жуулчдад сурталчилах зорилгоор шинээр үйл ажиллагаагаа эхлүүлж буй "Хэнгүн" ХХК-ний "Дөрвөн бэрх" жуулчны бааз нь малын дотор эрхтэн болох зүрхээр "Зүрхэн стэйк" хийж хоолны цэсэндээ тусган, үйлчлүүлэгчиддээ хүргэж байна. | | |
| 2 | Арга хэмжээ 1.2 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүнс, худалдаа үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулан хэлэлцүүлж, батлуулах, хэрэгжилтийг хангах. | Төлөвлөгөөний хэрэгжилийг хангах ажлыг зохион байгуулсан байна. | Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн ажлыг 90 хувьтай дүгнүүлсэн. | Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг өлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллана. | Засаг даргын захирамжаар ажлын хэсэг гарч төлөвлөгөө боловсруулах шатандаа байна. Ажлын хэсгийг 2 удаа хуралдуулахаар ажлын хэсгийн ахлагчид танилцуулсан боловч ажлын ачаалал ихтэй байсан тул хойшлуулсан. | 2024.03.01<br>2024.12.25 | |
| ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХАД ХЯНАЛТ ТАВИХ, ИРГЭН АЖ АХУЙН НЭГЖИД МЭРГЭЖЛИЙН АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГЧ ХАМТРАН АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 3 | Арга хэмжээ 1.3 Хүнсний аюулгүй байдал, нийтийн | Стандартыг хангаж ажиллахад заавар | Тохирлын гэрчилгээг 12 | MNS 6648:2016, | Стандарт хэмжил зүйн хэлтэсээс ажлын хэсэг иржс 2024 оны 05 дугаар сарын 6- | 2024.01.02<br>2024.12.31 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хоолны салбар, худалдаа үйлчилгээний стандартыг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах. | зөвлөгөө өгөх, зөвлөмж мэдээллээр хангасан байна. | хүнсний дэлгүүр, 1 кафе, 3 цайны газар, 2 үсчин, 1 талх нарийн боовны цех, 2 халуун усны газар буюу нийт 21 үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд олгосон. | MNS:5021-1:2019, MNS 4946:2019 стандартуудын шаардлагыг хангуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах. | наас 08-ны өдрүүдэд Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хоршоо хариуцсан мэргэжилтэнтэй хамтран худалдаа үйлчилгээний газруудад ажилласан. Ажиллах хугацаандаа 15 аж ахуйн нэгж, иргэний 15 худалдааны газарт “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ MNS 5021-1:2023” стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, 38 аж ахуйн нэгж, иргэний 37 худалдааны газар, 1 нийтийн хоолны газарт холбогдох стандартын чиглэлээр зөвлөмж зөвлөгөө өгсөн. Худалдаа үйлчилгээний 19 газарт тохирлын гэрчилгээ олгогдоод байна. 10 дугаар сарын 1,2-нд хүнсний 11 дэлгүүрт холбогдох стандартын чиглэлээр зөвлөгөө өгч хугацаа дууссан барааг дотоод хяналтаар устгуулан буцаалт хийлгэсэн.<br><br>Жуулчны баазуудыг 2 жил тутамд тохирлын үнэлгээнд хамруулах ажлын хэсэг 2024 оны 07-р сард ирж ажиллан 11 жуулчны баазад тохирлын үнэлгээнд MNS 6043:2019 стандартын шаардлагын дагуу бэлтгэсэн үнэлгээний хуудсыг ашиглан стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор үнэлж, шаардлагатай бичиг баримтуудыг ирүүлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. | | |
| 4 | Арга хэмжээ 1.4 Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар хяналт шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө, заавар өгч | Хяналт шалгалт хийж заавар зөвлөгөө өгсөн байна. | 2 удаа | Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хяналт | Сумын ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 8-ны өдрөөс 7 хоногийн хугацаанд 35 худалдааны газар, 10 хоол үйлдвэрлэгч, 3 талх нарийн боовны цех | 2024.01.02<br>2024.12.31 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтран ажиллах. | | | шалгалтыг 1-ээс доошгүй хийж зөрчил буурсан байна. | хамрагдсан. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг 7-14 хоногийн хугацаатай үүрэг өгч арилгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Хүнсний аюулгүй байдлын 3 сарын аяны хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газрын ЗДТГ хамтран 2024 оны 5-р сарын 24-ний өдөр ажлын хэсэг ирж 6 төсөвт байгууллагын гал тогоо, 3 талх нарийн боовны цех, 11 хүнсний худалдаа эрхлэгч нарт хяналт шалгалт хийн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа 28 хүнсний худалдаа эрхлэгч 3-р улиралд шалгалтанд хамрагдан 16 дэлгүүрээс 1590,100 төгрөгийн чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй, хадгалалтын хугацаа дууссан хүнсийг илрүүлэн дотоод хяналтаар устгал хийлгэсэн. | | |
| 5 | Арга хэмжээ 1.5 Хүнсний аюулгүй байдал, нийтийн хоол, худалдаа үйлчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх | Мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | Нийтийн хоолны чиглэлээр гал тогоотой 4 төсөвт байгууллага, 3 цайны газар, 2 түргэн хоол, 41 хүнсний худалдаа, 21 барааны дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна. | Мэдээллийн санг 100 хувь бүрдүүлэх. | Мэдээллийн санг шинэчилж хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хоол үйлдвэрлэлийн судалгааг гаргаж ХХААГ-т хүргүүлсэн. Сар болгоны 01-ний өдөр аж үйлдвэрийн мэдээг иргэн, аж ахуйн нэгжээс авч нэгтгэн сумын статистекийн мэргэжилтэнд гаргаж өгч байна.<br>Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр төсвийн болон хувийн хэвшлийн 11, талх нарийн боовны цех 3, хүнсний худалдаа эрхлэгч 40, барааны худалдаа эрхлэгч 20, үсчин гоо сайхан 12, оёдол 4, халуун ус 2, дугуй засвар 2, авто засвар 2, авто угаалга 1, эмийн сан 6 тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. | 2024.02.01<br>2024.12.16 | |
| “ИРГЭН, АЖ НЭГЖ, ХОРШООДОД АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГЧ ХАМТРАН АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Арга хэмжээ 1.6 Иргэн аж ахуй нэгж, хоршоонд арга зүйн зөвлөгөө өгч чадавхижуулах ажлыг зохион байгуулах. | Иргэн аж ахуй нэгж, хоршоо чадавхижан үйл ажиллагаа нь жигдэрсэн байна. | 3 хоршоо 1 удаагийн сургалтанд хамрагдсан. 1 хоршоо шинээр байгуулагдсан. | Хоршооны үйл ажиллагаа өргөжиж зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдсэн байх. | “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий нээлт, хангайн бүсийн арга хэмжээнд Улаанбаатар хот, Арвайхээр сум, Архангай аймгийн Эрдэнэбулган суманд зохион байгуулагдаж хоршооны төлөөлөл, малчин, банкны салбарын төлөөлөл, ЗДТГ-аас 14 хүн оролцсон.<br>Сумын Засаг даргын А/105 тоот захирамжаар “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг сурталчлан таниулах, зөвлөн туслах багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан ажиллаж 419 малчин өрх, 1325 малчид, иргэд, хоршооны төлөөлөлд мэдээлэл зөвлөгөө өгсөний дүнд 15 хоршоо шинээр байгуулагдан, мал аж ахуйн чиглэлээр төрийн банкнаас 15 хоршооны 74 малчин 36-60 сарын хугацаатай жилийн 6 хувийн хүүтэй 2,450.000.000 төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан. 2024.12.07-ны өдөр 3 хоног аймгаас ажлын хэсэг ирж 74 хоршооны үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 7 | Арга хэмжээ 1.7 Хоршоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагтай хамтран ажиллах, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчилахад дэмжлэг үзүүлэх брэнд бүтээгдэхүүнтэй болоход | Брэнд бүтээгдэхүүнтэй болж борлуулалт нэмэгдсэн байна. | Үзэсгэлэн худалдаанд оролцон 8,5 сая төгрөгийн борлуулалт хийн бүтээгдэхүүнээ сурталчилсан. | Үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчилан таниулах. | Сумын Засаг даргын удирдамжтай “Бат-Өлзий 100” бэлэг дурсгал, бэлгийн багц шалгаруулах үзэсгэлэн худалдааг 2024 оны 5-р сарын 22-ны өдөр зохион байгуулж 11 иргэн, аж ахуйн нэгж, хоршооны төлөөлөл хийсэн 63 нэр төрлийн бүтээгдэхүүнээрээ оролцсон.<br>Бат-Өлзий сум шилдэг сумаар шалгаран шагнал гардуулах ёслолын арга хэмжээний үеэр сумандаа үйлдвэрлэж байгаа 49 төрлийн бүтээл, | 2024.04.01<br>2024.11.01 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэмжин ажиллах. | | | | бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гаргаж иргэд, хүрэлцэн ирсэн зочидод дэлгэн үзүүлж 867,000 төгрөгийн борлуулалт хийсэн.<br>“Алтаннамар 2024” үзэсгэлэн худалдааг 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж 14 иргэн, 4 хоршоо, 1 албан байгууллага төмс, хүнсний ногоо, гар урлал, цагаан идээ, жимс жимсгэнэ, модны суулгац, талх, нарийн боов, түргэн хоол, оёдлын чиглэлээр 89 төрлийн бүтээгдэхүүнээр оролцон 8666,000 төгрөгийн борлуулалтыг хийсэн.<br>2024 он 09 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Өв” түншлэл намрын баяр 2024” үзэсгэлэн худалдаанд 2 хоршоо, 2 иргэн 21 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцон 3,2 сая төгрөгийн борлуулалт хийн оролцсон. /Зөгийн бал, эмийн ургамал, сүү цагаан идээ, төмс/<br>“Хүрхрээн чимэг” хоршоо байгуулагдан сав баглаа боодлыг шинэлэг байдлаар шийдэн цайны ээзгий, борцтой хийцтэй цайг тус бүр 1000 ширхэгийг хийж борлуулаад байна. Бүтээгдэхүүнийг 15 малчин өрхөөс цагаан идээ авахаас гадна тогтмол 1 ажлын байр бий болгосон.Тус хоршооны цайны ээзгий, борцтой хийцтэй цайг тус бүрд нь 400 ширхэгийг 100 жилийн ойн бэлгийн багцад шалгаруулан худалдан авалт хийн дэмжин ажилласан. | | |
| ЗОРИЛТ 2. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА | | | | | | | |
| 8 | Арга хэмжээ 1.2.1 Орон нутгийн иргэдийн үүсгэн байгуулсан аж ахуйн | Аж ахун нэгж, компанид үзүүлсэн дэмжлэгийн дүн | Хүнсний чиглэлээр үйл ажиллагаа | Гарааны бизнес эрхлэхтэй | Гарааны бизнес эрхлэж байгаа 2 аж ахуйн нэгжид Төрийн банк, ХААН банкаар дамжуулан бизнесийн зээлийг | 2024.04.01<br>2024.11.01 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгж, компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, гарааны бизнес эрхлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг үе шаттай, тогтмол зохион байгуулах | | эрхэлдэг 14 иргэн шинээр аж ахуй нэгж байгуулагдсан. | холбоотой хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлан таниулж ажиллах. | олгосон. Шинэ хоршоо хөдөлгөөний ажлын хэсэг байгуулагдан ажиллаж 419 малчин өрх, 1325 малчид, иргэд, хоршооны төлөөлөлд мэдээлэл зөвлөгөө өгсөний дүнд 15 хоршоо шинээр байгуулагдан, мал аж ахуйн чиглэлээр төрийн банкнаас 15 хоршооны 74 малчин 36-60 сарын хугацаатай жилийн 6 хувийн хүүтэй 2,450.000.000 төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан.<br>Бизнес эрхлэх, хоршиж нэгдэн ажиллах сонирхолтой 47 иргэн аж ахуйн нэгжид Бэст хөтөлбөрөөс 2, 3 улиралд 2 удаа компаний засаглал, хэрхэн хоршиж нэгдэж ажиллах, өргөжүүлэн ажиллах, шинэ санаа турших чиглэлээр сургалтыг ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан. | | |
| 9 | Арга хэмжээ 1.2.2 Орон нутгийн онцлогт тулгуурлан байгаль, нийгмийн шинжлэх ухааны танин мэдэхүйн контентыг бүтээж, олон нийтийн радио телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээн дэлгэрүүлэх. | Бэлтгэсэн контентын тоо | Иргэд, аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сумын иргэдэд бичлэг, зурган хэлбэрээр сумын группд байршуулсан. | 1-ээс дээш контент бэлтгэнэ. | Хүрхрээн чимэг" хоршооны цайны ээзгий, борцтой хийцтэй цайг танилцуулсан бичлэг хийн сумын группд байршуулсан.<br>Бат-Өлзий сумын 100 жилийн ойн арга хэмжээнд бэлгийн багцыг шалгаруулан ойн арга хэмжээнд оролцсон зочид төлөөлөгч нарт гарын бэлэг өгч суманд үйлдвэрлэсэн брэнд бүтээгдэхүүнийг сурталчилан таниулсан. | 2024.07.01<br>2024.10.25 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Арга хэмжээ 1.2.4 Хүнсний үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх. | Дэмжлэгт хамрагдсан үйлдвэр, аж ахуйн нэгжийн тоо, дэмжлэгийн хэмжээ. | Эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн хүүгийн дэмжлэгт нийт 62 иргэн аж ахуйн нэгж 3,119,6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. | Хүнсий үйлдвэр эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл болон (дэд бүтэц, ажлын байр, түрээсийн хөнгөлөлт гэх мэт) бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлсэн байна. | Хүнсний худалдаа эрхлэгч 19 иргэн, аж ахуйн нэгжид тохирлын үнэлгээ хийлгэн тохирлын гэрчилгээг олгуулж ажилласан. Архины тусгай зөвшөөрлийг 6 аж ахуйн нэгжид олгох ажлыг зохион байгуулсан.<br>Бат-Өлзий 100 жилийн ойн хүрээнд бэлгийн багц шалгаруулан "Хүрхрээн чимэг" хоршооны цайны ээзгий 400, борцтой хийцтэй цай 400, Жаргалхүү ХХК-ны зөгийн бал 400, шар тостой монгол архи 400 ширхэгийг тус тус худалдан авч дэмжин ажилласан.<br>Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 15 хоршоо шинээр байгуулагдан төрийн банкнаас 3 хоршоо хүнсний чиглэлээр 350.000,000 төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан. | 2024.07.01<br>2024.11.01 | |
| 11 | Арга хэмжээ 1.2.5 Сум орон нутагтаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, шалгарсан бүтээгдэхүүнийг улс, аймгийн үзэсгэлэн худалдаанд оролцуулахад дэмжлэг үзүүлсэн байх. | Улс, аймгийн үзэсгэлэн худалдаанд оролцуулсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо. | Үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. | Үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, шалгарсан бүтээгдэхүүнийг улс, аймгийн үзэсгэлэн худалдаанд оролцуулахад дэмжлэг үзүүлсэн байна. | Сумын Засаг даргын удирдамжтай "Бат-Өлзий 100" бэлэг дурсгал, бэлгийн багц шалгаруулах үзэсгэлэн худалдааг 2024 оны 5-р сарын 22-ны өдөр зохион байгуулж 11 иргэн, аж ахуйн нэгж, хоршооны төлөөлөл хийсэн 63 нэр төрлийн бүтээгдэхүүнээрээ оролцсон.<br>Бат-Өлзий сум шилдэг сумаар шалгаран шагнал гардуулах ёслолын арга хэмжээний үеэр сумандаа үйлдвэрлэж байгаа 49 төрлийн бүтээл, бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гаргаж иргэд, хүрэлцэн ирсэн зочидод дэлгэн үзүүлж 867,000 төгрөгийн борлуулалт хийсэн.<br>"Алтаннамар 2024" үзэсгэлэн худалдааг 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж 14 иргэн, 4 хоршоо, 1 албан байгууллага төмс, хүнсний ногоо, гар урлал, цагаан идээ, жимс жимсгэнэ, модны суулгац, талх, нарийн боов, түргэн хоол, оёдлын чиглэлээр 89 | 2024.04.01<br>2024.11.01 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төрлийн бүтээгдэхүүнээр оролцон 8666,000 төгрөгийн борлуулалтыг хийсэн.<br>2024 он 09 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Өв" түншлэл намрын баяр 2024" үзэсгэлэн худалдаанд 2 хоршоо, 2 иргэн 21 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцон 3,2 сая төгрөгийн борлуулалт хийн оролцсон. /Зөгийн бал, эмийн ургамал, сүү цагаан идээ, төмс/<br>"Хүрхрээн чимэг" хоршоо байгуулагдан сав баглаа боодлыг шинэлэг байдлаар шийдэн цайны ээзгий, борцтой хийцтэй цайг тус бүр 1000 ширхэгийг хийж борлуулаад байна. Бүтээгдэхүүнийг 15 малчин өрхөөс цагаан идээ авахаас гадна тогтмол 1 ажлын байр бий болгосон. | | |
| 12 | Арга хэмжээ 1.2.6 "Хөх сав, канистергүй сум, баг, өрх" хөдөлгөөн өрнүүлэх, малчдыг сүү цагаан идээгээ хүнсний зориулалтын саванд боловсруулах, хадгалах, тээвэрлэх чиглэлээр арга хэмжээ авах. | -Нөлөөллийн арга хэмжээний тоо,<br>-Зориулалтын бус савыг зориулалтын саваар сольсон айл өрхийн тоо. | Аймгийн хэмжээнд 2102 айл өрх, 90 байгууллагын гал тогоо, 62 нийтийн хоолны газар хуванцар савнаас татгалзсан. | Бүх сумд нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, зориулалтын бус савыг зориулалтын саваар сольсон айл өрхийн тоо урд оноос өссөн байна. | Зориулалтын бус хуванцар савны хор хөнөөлийн талаар 35 худалдааны газар, 10 хоол үйлдвэрлэгч, 3 талх нарийн боовны цехийн 64 иргэнд мэдээлэл хийж нарын авлага бэлтгэн хүргэсэн. "Зориулалтын бус хуванцар савнаас татгалзах талаар нөлөөллийн ажлыг жил бүр төлөвлөн зохион байгуулан ажилладаг энэ ажлын хүрээнд "Алтан намар 2024" үзэсгэлэн худалдаанд оролцон сум орон нутагтаа үйлдвэрлэл явуулж буй иргэд аж ахуйн нэгж, хоршооны 18 хүнд ган сав өгч урамшуулсан. | 2024.04.01<br>2024.12.25 | |
| 13 | Арга хэмжээ 1.2.7 Сумын төвийн усан хангамжийн эрүүл ахуйн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгалалтын | Хамгаалалтын бүс тогтоосон эсэх. | - | Хамгаалалтын бүс тогтоосон байна. | Усан хангамжийн эрүүл ахуйн эх үүсвэрийн хамгаалалтын 4 цэгт 8 ширхэг самбарын тэмдэгжүүлэлт хийж байршуулсан. | 2024.07.01<br>2024.10.25 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүс тогтоож тэмдэгжүүлэх. | | | | | | |
| ЗОРИЛТ 3. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 14 | Арга хэмжээ 1.3.1 Байгууллагын гадна дотор тохижилт болон өрөө тасалгааг тохижуулах. | Ажлын байр аятухтай болсон байна. | Ус буцалгагч, тавиур худалдан авч цэцэг тарьж өрөөгөө тохижуулсан. | Өөрийн албан өрөөнд 1-ээс доошгүй тохижилтын ажил хийсэн байна. | Малын үүлдэрлэг байдлын зургыг жаазлан өрөөгөө тохижуулсан. | 2024.07.01<br>2024.10.20 | |
| 15 | Арга хэмжээ 1.3.2 Ёс зүйг чанд сахих зөрчилгүй ажиллах. | Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих. | Зөрчил гаргаагүй | Цаг ашиглалтыг баримтлах, зөрчилгүй ажиллах. | Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж зөрчил гаргалгүй ажилласан. Цаг ашиглалтыг баримталж ажилласан. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 16 | Арга хэмжээ 1.3.3 Удирдах, удирдуулах зарчмыг мөрдөж, өгсөн үүрэг даалгаврыг цаг үед хийж, Засаг дарга, ЗДТГ-ын даргад тухай бүр танилцуулж ажиллах. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар хэрэгжүүлж, цаг үеийн ажилд идэвхтэй оролцсон байна. | Удирдлагаас өгсөн үүргийг цаг хугацаандаа хийж гүйцэтгэсэн. | Тухай бүр | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг биелүүлэн, мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 17 | Арга хэмжээ 1.3.4 Архив албан хэрэг хөтлөлтийн стандартыг баримтлан алдаа дутагдал зөрчилгүй ажиллах. | Архив албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллана. | Бичиг хэргийг стандартын дагуу хөтлөж, 5 баримт архивлаж өгсөн. | Архивт баримтаа хадгаламжийн нэгж болгон үдэж хавтаслан хуулийн хугацаанд өгөх. | Албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг судлан албан бичиг боловсруулах үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллаж байна.<br>2024 оны 2 сард бичиг баримтаа үдэж өгсөн. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 18 | Арга хэмжээ 1.3.5 Олон нийтийн арга хэмжээнд оролцох | Олон нийтийн арга хэмжээнд оролцсон байна. | 8 удаа арга хэмжээнд оролцсон. | Зохион байгуулагдаж байгаа олон нийтийн арга хэмжээнд оролцох | Хангайн бүсийн ЗДТГ-ын алба хаагчдын дунд зохион байгуулагдсан нөхөрсөг уулзалт тэмцээнд оролцож 3*3 сагсан бөмбөгийн тэмцээнд мөнгөн медаль хүртсэн.<br>Засаг даргын тамгын газрын эцэг эхийн зөвлөлөөс 2024 оны 05 дугаар сард | 2024.01.02<br>2024.12.31 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулсан “Гэр бүлдээ-Гэр бүлийн өдрийг зориулъя” арга хэмжээнд оролцсон.<br>“Улсын тэргүүний шилдэг” шилдэг сумаар шалгарч шагнал гардуулах арга хэмжээний бэлтгэл ажилд 6-р сард оролцсон.<br>Сумын 100 жилийн ойн арга хэмжээний хэв журмын хэсэгт орж ажилласан.<br>Малын тооллогын ажилд 3-р багт хувиарлагдан орж ажиллаж байна. | | |
| | Арга хэмжээ 1.3.5 Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (https://erp.e-mongolia.mn/)-ийг нэвтрүүлэх. | Дотоод удирдлагын системийг ашиглаж хэвшсэн байна. | Программыг татаж суулгасан. | Өөрийн мэдээллийг оруулах. | Өөрийн мэдээллийг А, Б маягтын дагуу оруулсан. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| | | | | | | | |
| ЗОРИЛТ 5. НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ) | | | | | | | |
| | Өгсөн үүрэг даалгавар | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | - | - | - | - | - | - | - |
| ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ | | | | | | | |
| 19 | Арга хэмжээ 2.1 Ил тод нээлттэй байдлыг ханган цахимаар болон мэдээллийн самбаруудад байршуулах. | Мэдээллээр хангасан байна. | 5 мэдээлэл байгууллагын самбарт байршуулсан | Цахим болон мэдээллийн самбарт өөрийн салбарын мэдээллийг ил тод байршуулах. | Байгууллагын мэдээллийн самбарт ЖДҮ, Шинэ хоршоо хөдөлгөөн, бусад 6 төрлийн мэдээлэл бэлтгэн байршуулан ажилласан. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 20 | Арга хэмжээ 2.2 Мэдлэг чадвараа нэмэгдүүлэх, сургалт сурталчилгаа | Сургалт хийж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна. | Онлайн 4 сургалт, танхимын 3 | Мэдээлэл бэлтгэн 1-ээс доошгүй | Аймгийн ХХААГазраас зохион байгуулсан 4 сургалт, сургалтанд тус тус хамрагдсан. 2-р улиралд шинэ хоршоо | 2024.01.02<br>2024.12.31 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хийх. | | сургалтанд тус тус хамрагдсан. | сургалт хийх, сургалтанд хамрагдах. | хөдөлгөөний талаар багийн ИНХ-аар иргэд малчдад мэдээлэл бэлтгэн хүргэсэн. | | |
| 21 | Арга хэмжээ 2.3 Мэдээ тайлангаа цаг тухай бүрд тайлагнах. | Хийж хэрэгжүүлсэн ажлаа тайлагнасан байна. | Мэдээ тайланг цаг тухай бүрт гаргаж өгсөн. | Тухайн сард хийсэн ажлаа илтгэх хуудсаар сар бүрийн 23-ны дотор ЗДТГ-ын даргад тайлагнасан байх. | 1,12-р сард хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, хөтөлбөрийн биелэлт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бодлогын бичиг баримтын биелэлтүүд, өөрт хамааралтай судалгаа, мэдээг гарган архив, албан хэргийн эрхлэгчид цаг тухай бүрд өгч ажиллаж байна. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 22 | Арга хэмжээ 2.4 Монгол бичгээр уншиж, бичиж сурах. | Монгол бичгийн хичээлд хамрагдсан байна. | 3 | Анхан шатны мэдлэгтэй болсон байна. | Монгол бичгийг бие даан судалж байна. Үсгүүдийг холбон уншиж эхэлсэн. | 2024.01.02<br>2024.12.31 | |
| 23 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг судлах. | Хуулийг судласан байна. | "Хөдөө аж ахуй, газар тариаланд шаардлагатай трактор худалдан авах" худалдан авах ажиллагааны нарийн бичгээр ажилласан | Худалдан авах ажиллагааны хууль, журмыг судлах. | Худалдан авах ажиллагааны хууль, журамыг уншиж судалсан. | 2024.01.02<br>2024.12.31 | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ,
ХОРШОО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Э.БАДАМХАНД 2024.12.06